



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулсан Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн зээлийн хэлэлцээр болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Б.Батзаяа Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Н.Энхбат Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн захирал

Гишүүдэд:

Б.Очирсүх Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

З.Цэрэнчимэг

Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч бөгөөд сайдын багцын ерөнхий нягтлан бодогч

Г.Бат

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн

Д.Намсрайжав

Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн

Т.Доржханд

Сангийн яамны Төслийн санхүүжилт зохицуулалтын газрын дарга /тохиролцсоноор/

Б.Төгөлдөр

Сангийн яамны Төслийн санхүүжилт зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/

| | |
|------------|--|
| Д.Гантулга | Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч /тохиролцсоноор/ |
| Б.Алтанцом | Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Аэронавигацийн үйлчилгээний газрын дарга |
| Н.Энхбат | Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагч |

2. Тендерийн шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Б.Батзаяа/-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Н.Энхбат/-д үүрэг болгосугай.

 А. ГАНСҮХ